



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 115

Эрдэнэт

Ээлжит хуралдаан
зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн Ээлжит IX хуралдааныг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.1.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай

1.2.Аймгийн 2017 оны төсвийн тодотгол, 2018 оны төсөв батлах тухай

1.3.Аймгийн 2018 оны төсвийн төслийн боловсруулалтад хийсэн аймгийн ИТХ-ын Төсөв санхүүгийн хөгжлийн хорооны санал, дүгнэлт

1.4.Аймгийн 2018 оны төсвийн төслийн боловсруулалт, орлого нэмэгдүүлэх, зардал хэмнэх талаар гаргасан Аудитын газрын санал дүгнэлт

1.5.Аймгийн хэмжээнд газрын харилцааны талаар 2017 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ, 2018 онд баримтлах чиглэлийн тухай

1.6. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тухай

1.7. Аймгийн ИТХ-ын байгууллагын 2017 онд хийсэн ажлын тайлан

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит IX хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Гурав.Хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

001000000259